

Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн сул ажлын байрны мэдээлэл

Нягтлан бодогч

Гүйцэтгэх үндсэн үүрэг:

Албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүрэг.

Цалин, нэмэгдэл хөлс:

Албан тушаалын сарын үндсэн цалин нь Төрийн үйлчилгээний албан тушаалын ТҮ-7 ангиллаар, Төрийн албаны тухай хууль, Засгийн газрын холбогдох тогтоолд заасан нэмэгдэл хөлс, урамшуулал, бусад нэмэгдлээс бүрдэнэ.

Ажлын байранд тавигдах шаардлага:

Дараах шаардлага, шалгуурыг бүрэн хангасан байвал зохино:

-Магадлан итгэмжлэгдсэн их, дээд сургуулийг нягтлан бодох бүртгэл, санхүү, эдийн засгийн мэргэжлээр бакалавр буюу түүнээс дээш зэрэглэлээр төгссөн байх;

-Хугацаа хэтэрсэн зээлийн өр төлбөргүй байх;

-Нягтлан бодогчоор ажилласан туршлагатай байх;

-Санхүүгийн өдөр тутмын бүртгэл хөтлөх, санхүү, татварын тайлан, тооцоо гаргах, хянах чадвартай байх;

-Компьютерийн хэрэглээний программыг бүрэн ашиглах чадвартай байх;

-Шударга, эерэг хандлагатай, багаар ажиллах чадвартай байх;

-Идэвхи санаачлагатай, бүтээлч шинийг эрэлхийлэх сэтгэлгээтэй хариуцлагатай байх.

Бүрдүүлэх материал:

-Төрийн албан хаагчийн анкет;

-Боловсролын баримт бичиг /эх хувиар болон хуулбарын хамт/;

-Иргэний үнэмлэх /хуулбарын хамт/;

-Өмнө нь ажиллаж байсан байгууллагын тодорхойлолт;

-Нийгмийн даатгалын дэвтэр /эх хувиар болон хуулбарын хамт/;

-Хугацаа хэтэрсэн өр төлбөргүй болохыг тодорхойлсон тодорхойлолт;

-Ял, шийтгэл эдлэж байгаагүй талаарх тодорхойлолт.

Дээрхи шаардлагыг хангаж байгаа иргэдийг Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн 405 тоотод бүртгэнэ.

Холбоотой асуудлаар 98116868 утсаар мэдээлэл авна уу.

ЦССҮТ